




АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газар

Эм хангамжийн газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн
ноцтой байдлын үеийн эм, эмнэлгийн
хэрэгслийн хангамж, зохицуулалтын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1
дүгээр хороо, UBH center, 8 дугаар
давхар

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн болон өнчин эм, төрөөс төлбөрийг хариуцах эмийн хангамж, хүртээмж, нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг хариуцах, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
2. Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн болон өнчин эм, төрөөс төлбөрийг хариуцах эмийн хангамж, хүртээмж, нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг хариуцах, мэдээллээр хангах;
3. Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
4. Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Өнчин эм, төрөөс төлбөрийг хариуцах эм, хэрэгцээ, санхүүжилтийг урьдчилан тооцох, хөнгөлөлттэй олгох эмийн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр шаардлагатай дүрэм, журмыг боловсруулах.	Хууль, дүрэм журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Монгол улсын хэмжээнд ховор тохиолдох өвчин, түүнд хэрэглэх эмийн нэр төрөл, үнийн судалгааг гаргах, хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудлаар санал боловсруулж, танилцуулах.	Судалгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хууль эрх зүй, үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулсан байна.	Г
	3.Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох үйл ажиллагааг сайжруулах, эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран ажиллана.	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна.	Г
	4.Төрөөс төлбөрийг хариуцах эм хэрэглэж байгаа хүн амын судалгаа, эмийн хангамж, хүртээмжийн судалгааг тогтмол хийж, мэдээний сан үүсгэн, дүн шинжилгээ хийж, шаардлагатай мэдээллээр удирдлага, холбогдох байгууллагыг хангана.	Хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тусламж үйлчилгээ, тандалт судалгаанд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэгцээ, шаардлагатай санхүүжилтийг урьдчилан тооцох.	Судалгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэрэгцээг тооцон, санхүүжилтийн хэмжээг тооцсон байна.	Г



	2.Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх.	Шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.	Г
	3.Зах зээл дэх болон эрүүл мэндийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын нөөцийн мэдээг өдөр бүр шаардлагатай тохиолдолд тодорхой цагийн давтамжтай авах зохицуулалтыг хангаж ажиллах, программ хангамжийг ашиглах.	Үйл ажиллагааг сайжруулах, асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж танилцуулсан байна.	Г
	4. Нөөцийн бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх асуудлаар эм хангамжийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах.	Нөөцийн мэдээ цаг хугацаандаа үнэн зөв гарч, мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ	Г
	5.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлыг үед нөөцийг зөв зохистой ашиглах асуудлаар холбогдох саналыг боловсруулж, танилцуулах.	Хууль, дүрэм журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль бусад холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Хууль, дүрэм журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Хариуцсан асуудлын чиглэлээр бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагаас гаргуулан авч нэгтгэх, танилцуулах.		
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Сар, улирал, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох албан тушаалтантай гүйцэтгэлийн гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах.	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна.	Г
	2.Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах.	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна.	Г
	3.Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Шаардлагын түвшинд хэрэгжүүлсэн байна.	Г
	4.Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г



	5.Газрын даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлэх ;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, үнэлгээ.	Г
--	---	---	---

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- эм зүй /0916/ - эрүүл мэндийн эдийн засаг - эдийн засаг /0311/		
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн байх_		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажиллаж байсан бол давуу тал болно.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	
	Асуудал шийдвэрлэх	- асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах, үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах.	
	Бусад	- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах.	


IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Эм хангамжийн газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>
	1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бусад газар, хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн; 2.Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, тэдгээрийн ажлын албаны холбогдох албан



	тушаалтан; 3.Нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан; 4.Төрийн бус байгууллага, Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн ажилтан; 5.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ <i>М.М.Исмаев</i> Л.НАМХАЙНОРОВ 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо 21 03 17 Дугаар 102
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2021.03.26 Дугаар: А/15  ДАРГА..... (Гарын үсэг) <i>Б. Цэцэгсайхан</i> (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр	

